



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/21


Улаанбаатар хот

### Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар цэцэрлэгийн данс бүртгэлд эргэлтийн бус хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.7, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 5,228,500 /таван сая хоёр зуун хорин найман мянга таван зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлдээ бүртгэн авахыг Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар цэцэрлэг /Н.Хоролмаа/ -т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Сонгинохайрхан дүүргийн 106 дугаар цэцэрлэг /Н.Хоролмаа/ -т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т тус тус даалгасугай.

ДАРГА  Д.ОДНАСАН  
ТТА-2371



ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАС

1. Шийдвэрийн тухай мэдээлэл

д/д	Захиргааны шийдвэрийн төрөл	Шийдвэрийн дугаар	Шийдвэр гаргасан албан тушаалтан	Захиргааны шийдвэрийн товч утга
1	Тушаал	A/22	Газрын дарга Ч.Однасан	Хөрөнгө актлах

2. Шийдвэр гаргахад оролцогчийн тухай мэдээлэл

д/д	Захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагчийн		Сонирхлын зөрчилтэй эсэх	Санал	Гарын үсэг	Он сар өдөр
	Албан тушаал	Нэр				
1	Орлогч дарга	Д.Ариунбаатар	✓✓✓✓			3/25
2	Хэлтсийн дарга	Д.Итгэл	✓✓✓	Үл оролцох		1/25
3	Хуулийн зөвлөх	А.Нарантуяа	✓✓✓	—		4/25

ДАГАЛДАХ ХУУДАС ХӨТӨЛСӨН:

Өмчийн бүртгэл мэдээллийн хэлтсийн Мэргэжилтэн

.......... /О.Батбаяр/